



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх газар (хурандаа А.Алтанбагана)-т даалгасугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2006 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн “Хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгөх дотоод журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Г. АРИУНБУЯН



00000467



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Онцгой байдлын байгууллагын үндсэн зорилт, чиг үүрэг, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гамшгийн аюул, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх болон гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх эрх, үүргийг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журам нь Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиуд, Онцгой байдлын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журам, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм болон бусад хууль, дүрэм, журамтай нийцсэн байна.

1.3. Онцгой байдлын байгууллагаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцахад дараах зарчмыг баримтална.

1.3.1. байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээ, мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байх;

1.3.2. байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой байх;

1.3.3. хүний нэр төр, алдар хүнд, байгууллага, хувь хүний нууц, оюуны өмчийн эрхэд халдахгүй байх;

1.3.4. онцгой байдлын байгууллагын нэр хүндэд харшлахгүй байх;

1.3.5. үнэн зөв, бодитой байх;

1.3.6. олон нийтэд хэрэгцээтэй, ойлгомжтой, хүртээмжтэй байх;

1.3.7. мэдээллээр хангах ажиллагаа шуурхай, хуулийн хүрээнд байх;

Хоёр. Мэдээллийг олон нийтэд хүргэх, түгээх

2.1. Онцгой байдлын байгууллагаас Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үндсэн арга нь олон нийтийн сүлжээ (твиттер, фэйсбүүк... гэх мэт), телевиз, сонин, радио, үүрэн холбооны оператор компаниуд, байгууллагын болон мэдээллийн бусад цахим хуудсууд, байгууллагын мэдээллийн самбар, хэвлэлийн бага хурал, телевизийн шууд нэвтрүүлэг, хэлэлцүүлэг зэрэг хэлбэртэй байна.

2.2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын үндсэн зорилт нь байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, гамшгаас хамгаалах төрийн

бодлого, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэх, гамшгийн нөхцөл байдлын цаг үеийн мэдээллийг олон нийтэд шуурхай хүргэхэд чиглэгдэнэ.

2.3. Мэдээллийг олон нийтэд түгээх арга хэмжээг дараах нэгж, албан тушаалтан хариуцна.

2.3.1. Онцгой байдлын ерөнхий газарт: Олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгж /цаашид "ОНХАХН" гэх/,

2.3.2. Нийслэлийн онцгой байдлын газарт: Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгж, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтнүүд,

2.3.3. Төв, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэст: Газрын урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгжийн дарга, ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн тус тус хэрэгжүүлнэ.

2.4. Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, нэгжийн дарга, ахлах мэргэжилтэн нь хэвлэлийн хурал, ярилцлага өгөх гэж буй эрх бүхий албан тушаалтныг шаардлагатай мэдээ мэдээлэл, тоо баримт, материалаар хангана.

2.5. Тухайн бүс, нутаг дэвсгэрт гарсан гамшиг, аюулт үзэгдэл, осол, эрэн хайх, аврах, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааны талаарх мэдээлэл, фото зураг, дүрс бичлэгийг бүсийн төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагын Урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгж, ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан ОНХАХН-д шуурхай, цаг алдалгүй хүргүүлнэ.

2.6. Онцгой байдлын байгууллагын газар, хэлтэс, анги байгууллагууд зохион байгуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой шаардлага хангасан мэдээ, мэдээллийг тухай бүр ОНХАХН-д шуурхай хүргүүлнэ.

2.7. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг нэгдсэн бодлого, удирдлага зохион байгуулалтаар хангаж, энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

2.8. Онцгой байдлын байгууллагын нэр төрд халдсан буруу ташаа мэдээ, мэдээллийг залруулах, олон нийтэд албаны талаар зөв ойлголт, мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор төлбөрт мэдээ мэдээлэл, ярилцлага, нийтлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж болно.

2.9. Төлбөрт мэдээ, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түгээх хэвлэл мэдээллийн байгууллагыг сонгохдоо захиалагч, үзэгч, сонсогчдын тоо, хүртээмжийн байдал, хэвлэгдэн гардаг тоо ширхэг, үнийн санал зэргийг харгалзан ОНХАХН сонгож, Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга баталгаажуулна.

2.10. Газар, хэлтэс, нэгжийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулах төлбөртэй зар сурталчилгаа, нийтлэл, орчуулга, ярилцлагыг холбогдох газрын дарга нарт танилцуулж зөвшөөрөл авна. Зөвхөн зөвшөөрөгдсөн материалыг ОНХАХН хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд түгээнэ.

Гурав. Мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан

3.1. Дараах эрх бүхий албан тушаалтан Онцгой байдлын байгууллагыг төлөөлж хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтэд мэдээлэл өгнө. Үүнд,

3.1.1. *Байгууллагын бодлого, стратегийн түвшний мэдээллийг:*

- ОБЕГ-ын дарга
- ОБЕГ-ын тэргүүн дэд дарга
- ОБЕГ-ын дэд дарга нар

3.1.2. *Гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлээр:*

- Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
- ОБЕГ-ын дарга
- ОБЕГ-ын тэргүүн дэд дарга
- ОБЕГ-ын дэд дарга нар
- Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга
- Гамшгийн шуурхай удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга
- Гал түймэртэй тэмцэх асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга
- Гамшгийн эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга

3.1.3. *ОБЕГ-ын даргын зөвшөөрлөөр:*

- УОК-ын нарийн бичгийн дарга
- Тухайн аюулт үзэгдэл, ослын голомтод эрэн хайх, аврах ажиллагааг удирдаж буй удирдах албан тушаалтан
- ОНХАХН-ийн дарга

3.1.4. *Улсын онцгой комиссын хандив, тусламжийн мэдээлэл, улсын нөөцтэй холбоотой асуудлаар ОБЕГ-ын даргын зөвшөөрлөөр:*

- ОБЕГ-ын тэргүүн дэд дарга
- Улсын нөөцийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга

3.1.5. *Цаг үеийн нөхцөл байдлын үед:*

- Холбогдох газар, хэлтсийн дарга, удирдлага
- ОНХАХН-ийн дарга, ахлах мэргэжилтэн

3.1.6. *Тухайн бүс, нутаг дэвсгэрт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаатай холбоотой асуудлаар:*

- Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, дэд дарга
- Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгжийн дарга
- Бүсийн төвийн захирагч
- Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын дарга, захирагч, Урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан нэгжийн дарга, ангиллын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн.

Дөрөв. Олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжийн эрх, үүрэг

4.1. Хэвлэл мэдээллийн байгууллагыг Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, албадаас ирүүлсэн мэдээллийн найруулга, агуулга, боловсруулалтад хяналт тавих, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгуулах,

4.2. Байгууллагын үйл ажиллагаа, гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын талаарх цаг үеийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод, үнэн зөв, шуурхай хүргэх,

4.3. Цаг агаарын аюулт үзэгдэл, болзошгүй аюул, ослын тухай мэдээлэл, сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /телевиз, сонин, албаны болон мэдээллийн сайтууд, үүрэн холбооны хэрэгсэл, олон нийтийн сүлжээ/-ээр дамжуулан шуурхай түгээх,

4.4. Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу шаардлагатай тохиолдолд хэвлэлийн бага хурал зохион байгуулах, няцаалт хийх, мэдэгдэл гаргах,

4.5. Олон нийтэд хүргэх мэдээллийг холбогдох газар, хэлтсээс авч нэгтгэх, удирдлагыг мэдээллээр хангах,

4.6. Байгууллагын стратегийн зорилго, зорилт, өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг албаны цахим хуудсанд тухай бүр байршуулан олон нийтэд хүргэх,

4.7. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, удирдлагатай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан аливаа сөрөг, ташаа мэдээлэл, гүтгэлэгт ОНХАХН-ээс дүн шинжилгээ хийж, холбогдох газар, хэлтсийн даргад нэн даруй танилцуулж, шаардлагатай хариу арга хэмжээг авах,

4.8. Шаардлагатай гэж үзвэл ОНХАХН-ийн дарга хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдээс ирүүлсэн мэдээ, мэдээлэл авах, уулзаж ярилцах тухай хүсэлтийг амаар болон бичгээр авч холбогдох төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, албадын дарга нарт хүргүүлэх,

4.9. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд зөв, зэрэгээр сурталчлах, гавьяа байгуулсан, тэргүүний шилдэг хамт олон, анги, салаа, алба хаагчдын үйл хэргийг сурталчлах, албаны нэр хүндийг өргөх нийтлэл, материал бэлтгэн олон нийтэд хүргэх, шинэ, санаа, сургамж, сайн туршлагыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлэх,

4.10. Мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан нь хувцаслалт, цэрэгжилт, харилцаа, хэл ярианы соёлд онцгой анхаарах үүрэгтэй.

4.11. Мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан нь Онцгой байдлын байгууллагын албан ёсны байр суурь, бодлого үйл ажиллагаа, нэр хүндтэй холбоо бүхий мэдээлэл, хэвлэгдэн гарсан нийтлэлийн талаар тайлбар, тодруулга, ярилцлага өгөх,

4.12. ОНХАХН нь ОБЕГ-ын бүтцийн нэгжүүд болон бүсийн төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагаас холбогдох мэдээ, материал, тоо баримтыг шаардлага хангуулан тухай бүр шуурхай татан авах эрхтэй.

Тав. Мэдээ, мэдээлэл авах тухай хүсэлт хүлээн авах, түүнийг хянан шийдвэрлэх

5.1. Хүн, хуулийн этгээд Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл авах тухай хүсэлтийг Олон нийттэй харилцах асуудал хариуцсан нэгжид гаргана.

5.2. Мэдээ мэдээлэл авах тухай хүсэлт гаргасан этгээдэд тавих шаардлага:

5.2.1. Хүсэлт гаргагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын болон цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын хуулбарыг хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

5.2.2. Хүсэлт гаргагч нь хуулийн этгээд бол байгууллагын нэр, хаяг болон цахим шуудангийн хаяг, улсын бүртгэлийн дугаарыг бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

5.2.3. Хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх, холбогдох хууль тогтоомж, бусдын хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх, авах мэдээллээ бодитой тодорхойлно.

5.3. Хүсэлт гаргагч этгээдэд дараахь зүйлийг хориглоно.

5.3.1. Хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхолд харшилсан, хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосон мэдээ, мэдээллийг шаардах,

5.3.2. Олж авсан мэдээ, мэдээллийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй байдлаар аль ч хэлбэрээр мэдээлэх, нийтлэх,

5.3.3. Албаны шугамаар олж авсан байгууллагын онцлогтой холбоотой нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд хор уршиг учруулж болохуйц нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй бусдад задруулах,

5.4. Хүсэлтийг шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор хянан үзэж хүсэлт гаргасан этгээдэд хариу өгөх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэхүү хугацаа дээд шатны дарга 3 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

Зургаа. Бусад зүйл

6.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нийгмийн сүлжээнд байгууллагын нууц, албаны нэр хүндтэй холбоотой, байгууллагын удирдлага, алба хаагч, ажилтны нэр хүндэд халдсан, олон нийтэд буруу ташаа ойлголт төрүүлэх мэдээ, мэдээлэл нийтлэхийг хатуу хориглоно.

6.2. Нийгмийн сүлжээнд албаны хувцастай зураг нийтлэхгүй байх, албаны хаягаар улс төрийн нам, эвслийг дэмжих, эс дэмжих талаар нийтлэл, мэдээлэл бичихгүй, түгээхгүй байх.

6.3. Онцгой байдлын байгууллагын алба хаагчаас эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй задруулсан мэдээ, мэдээлэл нь байгууллага, албан тушаалтанд ноцтой, хор уршиг учруулсан, нийгэмд эмх замбараагүй байдал үүсгэсэн, албаны нэр хүндийг илт гутаасан үйлдэл, эс үйлдэхүй нь тогтоогдвол сахилгын арга хэмжээ авах үндэслэл болно.

6.4. ОНХАХН-ээр дамжаагүй, эрх бүхий албан тушаалтнаар хянагдаагүй буруу, ташаа мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгсөн алба хаагчид хариуцлага тооцно.

6.5. ОНХАХН болон эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй байгууллага, албан тасалгаанд хэвлэл, мэдээллийн ажилтнуудыг нэвтрүүлэхийг хориглоно.

Долоо. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн холбогдох албан тушаалтныг зөрчлийн шинж байдлыг харгалзан эрх бүхий албан тушаалтнаас хууль тогтоомжид заасан хариуцлага тооцно.

---oOo---